

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ЗӨВЛӨМЖ

2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр

Арвайхээр

Хайрхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын
2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ
үнэлгээний тухай

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс 90.5 хувиар дүгнэсэн.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авах үйл явцын хувьд аймгийн Засаг даргын 2015 оны а/149 дүгээр захирамжийн дагуу хийгдэж, мөрдөн ажиллаж байгаа сайн талтай байна. 2023 онд шинээр бүртгэл хяналтад авсан орон нутгийн шийдвэр (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын шийдвэр) хангалттай хэдий ч үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа бодлого шийдвэрийн (Засгийн газрын тогтоол, засгийн хуралдааны тэмдэглэл гэх мэт) хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цахим бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулж, шийдвэрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эсэхэд хяналтыг тогтмол хийж ажиллахыг зөвлөж байна. Цахим мэдээллийн сан нь холбогдох шийдвэрийн хяналтад авагдсан болон хяналтаас хасагдсан байдал, тухайн шийдвэрийн хэрэгжилт тогтмолжсон эсэх, хүчингүй болсон эсэх гэх мэтээр он оноор ангилах, бүртгэлийг сайжруулахад чиглэгдэж байгаа тул уг үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай. Иймд цаашид байгууллага бүрээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цахим сангийн болон нэгдсэн бүртгэл хяналтыг сайжруулах, шинээр мөрдөгдөж байгаа хуулийн хяналт, бүртгэлийг нэмэгдүүлж, эзэнжүүлэх, хэрэгжилтийг тайлагнасан байхад анхаарах. Энэ чиглэлээр бусад байгууллага, албан хаагчдыг арга зүйгээр хангаж ажиллах.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлагналт хэт товч, үр дүн, үр нөлөөг тооцоолоогүй, тайлангийн чанар хангалтгүй байгаад дүгнэлт хийж, тайлагналтыг үр дүн, үр нөлөөнд тулгуурлаж бичих чадварт бүх албан хаагчдыг сургах, чадавхжуулах асуудалд тодорхой ахиц гаргаж ажиллах шаардлагатай байна.

Аливаа шийдвэрийн хяналтад авсан тухайн заалтын хэрэгжилтийг тайлагнахдаа уялдааг маш сайтар хангаж оновчтой тайлагнахад анхаарах.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 94.7 хувиар үнэлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс 90.0 хувь болгож буурууллаа. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс 89.0 хувиар дүгнэлээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүний хөгжлийн бүлэгт төлөвлөсөн зорилт, арга хэмжээний тодорхой хэмжээнд гүйцэтгэж ажилласан байна.

Үндэсний бахархал, өв соёлын бүлэгт угийн бичгийн хөтлөлт, монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлэх ажил сум орон нутагтаа тодорхой ажил тухайлбал Монгол бичгийн сургалт, төрөл бүрийн бичиглэлийн хэлбэрүүдээр уралдааныг зохион байгуулсан байна. Соёлын төвийн үйл ажиллагаа харьцангуй жигд, хүртээмжтэй үйл ажиллагаа явуулж байна.

гэж үзлээ. Цаашид номын фондын баяжилтыг тогтмол хийж, номоор дамжуулан ард иргэдийг соён гэгээрүүлэх, соёлын ваучераар хүүхдүүдэд үйлчлэх зэрэг ажилд санаачилга гаргаж, үр дүнтэй ажиллах шаардлагатай байна.

Мөн дуу хөгжмийн багшийг орон тоогоор ажиллуулах, сумын өөрийн гэсэн соёлын брэнд, эвенттэй болох, ажилтан албан хаагчдыг чадавхжуулах олон талт арга хэмжээг авах, Шамбалын орон уран зургийн галерейн баяжилтыг хийж ажиллахыг зөвлөж байна.

Эрүүл мэндийн салбарт ажиллах орчин нөхцөл сайжирч, ажиллагсдын сэтгэл ханамж дээшилсэн нь ажлын ахиц үр дүнд нөлөөлсөн гэж үзэж байна.

Тухайлбал үзлэг оношилгоо эрт илрүүлэлтийн хувь сайжирсан, мобайл технологи болон эхо үзлэг оношилгоо хийх, мэргэшсэн лаборантоор хийлгэж байгаа анхан шатны шилжилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох ажил, цэргийн насныхны эрүүлжүүлэлт явц шаардлага хангасан, чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлсэн гэж үзэж байна. Харин олон нийтийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, өсвөр үе рүү чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа оновчтой төлөвлөгдөж үр дүнтэй ажил хийгдээгүй байна. Цаашид гүйцэтгэлийн санхүүжилтийг улам бүр оновчтой шийдвэрлэх, хүний нөөцийг тогтвортой барих, нийгмийн асуудал дээр анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна. Мөн шүдний эрүүл мэндийн талаар хүүхэд, багачууд болон насанд хүрэгчдийн дунд хүртээмжтэй ажлыг зохион байгуулах, сэтгэцийн эрүүл мэнд рүү чиглэсэн хорт зуршилтай холбоотой ажил үйлчилгээ жигдрүүлж ажиллах нь зүйтэй. Мөн UP TO DATE системийг ашиглах, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах, эмч, сувилагчдыг бэлтгэх зэрэг хүний нөөцтэй холбоотой ажлуудыг зохион байгуулж ажиллахыг зөвлөж байна.

Мэргэжлийн спорт болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлын хүрээнд аймаг, улс, бүсийн чанартай тэмцээнүүдийг чанартай зохион байгуулж оролцоог бүрэн ханган ажилласан явдал нь сайн жишээ болжээ.

Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 377 хүүхэдтэй, 52 багш ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна. Сургалтын орчны хувьд стандарт шаардлага хангасан, цэвэр бохир шугамын инженерчлэлийг оновчтойгоор шийдвэрлэсэн байна.

Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн үнэлгээгээр 2 дугаар түвшинд шалгагдсан, ЭЕШ-ын оноогоор 5 дугаарт орсон зэргээс дүгнэхэд багш нарын ур чадвар боломжийн хэмжээнд байна гэж хэлж болохоор байгаа боловч сургуулийн дотоод орчин нөхцөл, өнгө үзэмж, мэргэжлийн секцүүдийн самбар зэргийг бүтээлч сэтгэлгээгээр баяжуулсан байдал дутагдалтай байна. Мөн байгалийн ухааны лабораторийн дадлагын хичээлүүдийн оролт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Харин нийгмийн ажилтан мэргэшсэн, шаардлагатай төлөвлөгөө, хөтөлбөр сайтай, тайлагналт хэвийн, сурагчдын хөгжил рүү чиглэсэн клубуудын үйл ажиллагаа сайн, хүүхэд хамгаалал, гэр бүлийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон, шатар хөтөлбөрийн хүрээнд тусгайлсан төлөвлөгөөтэй ажиллаж байгааг сайшаан тэмдэглүүштэй байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсрол тэгш харуулах бодлогын хүрээнд гурван хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ГТС боловсруулж ажилласан байна.

Мөн сургуулийн номын сангийн үйл ажиллагаа тогтмолжуулж, фонд баяжилтыг нэмэгдүүлж, стандартыг хангуулах, сурагчдыг уншихуйн дадалд сургах, уншихаар дамжуулан хөгжүүлэх асуудалд анхаарах.

Тэтгэвэрт гарсан багш нарыг ажиллуулж байгаа асуудалд анхаарч сумын хэмжээнд хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг гаргаж ажиллах.

Насан туршдаа суралцахуйн үйл ажиллагааны хүрээнд гаргасан судалгаагаар 15-46 насны 19 хүн бичиг үсэг тайлагдаагүй байгаа нь нийт хүн амтай харьцуулахад өндөр үзүүлэлт байна. Иймд бичиг үсэггүйчүүдийг бичиг үсэгт тайлагдаулах талаар төлөвлөгөөт арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд стандарт хангасан сайн үйл ажиллагаатай байна. Хүний нөөцийн бүрдэл хангалттай, сургалт хөгжлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Сургуулийн өмнөх байгууллагын орчин нөхцөл, стандартад нийцсэн шинэ өргөтгөлтэй болж чанар хүртээмж дээшилсэн байна. Цаашид хүрсэн түвшингөө илүү ахиулж, амжилт гаргаж ажиллахыг хүсье.

Хүүхэд хамгааллын хүрээнд дотуур байрны камеруудыг нэмэх, хүчин чадлыг сайжруулах, гараас гарт зарчмыг хэрэгжүүлэх, БШУГазрын дотуур байрны журналыг бүрэн дүүрэн хөтөлж хэвшихийг зөвлөө.

Хүүхэд хамгааллын хүрээнд нээгдсэн кейс цөөн, хаалт харьцангуй өндөртэй үйл ажиллагаа явуулж байна. Багш айлчлалын хүрээнд эрсдэлтэй болон өндөр эрсдэлтэй хүүхдийг илрүүлж анхаарал тавьж ажилласан байна.

Залуу гэр бүлүүдийн анхдугаар зөвлөгөөний зохион байгуулж, 24 гэр бүлийг оролцуулсан явдлыг онцлууштай байна. Мөн залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүрээнд түр болон байнгын ажлын байр 90-г бий болгосон байна. Халамжаас хөдөлмөрт концевцийн хүрээнд сүүлийн жилүүдэд 36 талонтой өрхөөс 19 өрх болгож бууруулсан байна. Цаашид байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд шинээр үйлчилгээ, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүн амыг татан төвлөрүүлэх, эдийн засгийг тэлэх тал дээр тусгай төлөвлөлт гаргаж үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ХАБЭАЗөвлөл харьцангуй бүтээлч үйл ажиллагаа явуулсан байна. Харин Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөрийг эрчимжүүлэх шаардлагатай байгааг зөвлөж байна.

Ахмад руу чиглэсэн үйл ажиллагаа хэвийн, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд санаачлагатай ажиллажээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн эдийн засгийн бүлэгт төлөвлөсөн үйл ажиллагаанууд хугацаандаа хийгдэж, зорилтот жилийн үйл ажиллагаатай уялдуулан хийсэн ажлууд нь үр дүнтэй хэрэгжсэн байна гэж үзлээ.

Сумын хэмжээнд 429.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 140.1 хувиар давуулан биелүүлж амжилттай ажилласан байна.

Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн ажлыг зохих түвшинд хийж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлогын хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагаануудыг цаг хугацаанд нь хуулийн хүрээнд хэрэгжүүлж ажилласан байна. Ёс зүй хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх хүрээнд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй байгаа бөгөөд цахимд суурилсан төрийн үйлчилгээг орон нутгийн түвшинд санаачлага гарган ажилласан байна. Цаашид уг ажлыг тогтмолжуулах, сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Эрх зүйн боловсролтой иргэн, авлигагүй засаглалыг хөгжүүлэх ажлын хүрээнд аймгаас дэвшүүлсэн бодлого хөтөлбөрийг хангалттай хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн Улаан загалмайн хороотой хамтарч төрийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж тодорхой үр дүн гаргаж ажилласан. тухайлбал аварга малчдыг сонгохдоо Улаан загалмайн нийгэмлэгийн гишүүн байх, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлсэн, нийт 350 гишүүнчлэлийн 3160.0 сая төгрөгийн төвлөрүүлсэн байна. Үүнээс онцгой гишүүн 67, мөнгөн гишүүн 1, энгийн гишүүн 282 иргэд байна. Мөн нэг иргэн 3 сая төгрөгийн 33 толгой мал хандивласан нь онцлог хүмүүнлэгийн мэдрэмжтэй үйл ажиллагаа болжээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн ногоон хөгжил, аялал жуулчлалын бүлэгт усны нөөцийг бий болгох үйл ажиллагааны хүрээнд 3 худгийг шинээр өрөмдөж 22.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн, ойн хөнөөлт шавжийн тархалтыг хязгаарлаж, 125 га-д химийн аргаар устгал хийсэн нь үр дүнтэй ажил болжээ.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төлөвлөсөн, зохион байгуулсан шинэлэг зүйлүүд байхгүй байгаад анхаарах. Цаашид аялал жуулчлалын маршрутын шинэ зам боломжийг нээхэд санаачилгатай ажиллах, үдлэх хоноглох газрын төлөвлөлтийг баталгаажуулах, нутгийн брэнд, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу оновчтой тайлагнаагүй, үр дүн тооцоогүй, хэрэгжүүлэх ажлыг санаачлан зохион байгуулаагүй.

БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:

Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг орон нутагтаа сайн зохион байгуулсан. Гэрээний биелэлтийг орон нутгаас 96.1 хувиар дүгнэсэн бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хэсэг 90.0 хувиар дүгнэв.

Гэрээний хэрэгжилтийг тайлагнахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу оновчтой тайлагнаагүй, үр дүн дурдаагүй, Засаг дарга даргын нэрийн өмнөөс бус мэргэжилтний зүгээс тайлагнасан. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой санаачилга гаргаагүй.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт:

Төрийн албан хаагчдыг сургах, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс 91.0 хувиар дүгнэлээ.

Ажлын байран дээр хөгжих сургалтад хувь хүний хөгжил рүү чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, эрүүл идэвхтэй ажиллаж амьдрах нөхцөлийг сайжруулахад тодорхой арга хэмжээ авч ажилласан байна. Цаашид ажлын байран дээр тасралтгүй хөгжих сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний ажилтнууд, суманд шинээр төрийн албанд шинээр орж байгаа залуучуудад зориулсан сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зэрэг холбогдох баримт бичгүүдийг танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулж ажиллахыг зөвлөж байна.

Засаг даргын Тамгын газар болон бусад төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг 87.0 хувийн хэрэгжилттэй дүгнэлээ. Сумын Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орон нутагт баримталж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээг тусгасан гэх боловч арга хэмжээнийх нь томъёолол байхгүй, тодорхойгүй байгаа нь төлөвлөлт хийхдээ маш хайнга хандсаныг илэрхийлж байна. Арга хэмжээний томъёолол тодорхойгүй байхад тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшнээ юунд үндэслэж гаргаж байгааг харах боломжгүй байна. Иймд цаашид эдгээр дутагдлыг гаргахгүй, албан хэрэг хөтөлөлтийн стандартыг бүрэн хангаж ажиллахыг анхааруулж байна.

Төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлангийн хувьд боловсруулалт, тайлагналтын чанар ерөнхийдөө хангалттай байгаагүй ч үндсэн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны чиглэлээ боломжийн түвшинд тодорхойлж ажилласан сайн татай байна. Цаашид төлөвлөлтөд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшний төлөвлөлт нь харилцан уялдаатай байх, тэдгээртэй уялдан биелэлт, үр дүнгээ тооцож тайлагнасан байхыг бүх байгууллага, албан хаагчид анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа орон нутгаас баримталж байгаа холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, аймгаас өгсөн чиглэл, арга хэмжээний төлөвлөлтийг өөрийн сум орон нутгийн онцлогт нийцүүлэн томъёолоход анхаарах.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ижил нэршилтэй, ижил утгатай, бие биеэ агуулсан утгатай зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгон тодорхойлох;

- Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай, нэг арга хэмжээнд 2-оос доошгүй байхаар тодорхойлох;

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд (Тамгын газрын) бодлого зохицуулалтын хүрээний гол арга хэмжээний төлөвлөлтүүдийг хийдэг байх (албан хаагч тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчилсан арга хэмжээнүүд орж байгаа учраас үйл ажиллагаа нэг бүрийг тусгах шаардлагагүй)

-Албан хаагчийн болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төсөв тавигдсан арга хэмжээнүүд байгаа бөгөөд гүйцэтгэл үр дүнд тухайн төсвийн гүйцэтгэлийг тусгаж тайлагнахгүй байгааг анхаарах.

-Төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, төлөвлөлтөд хяналт тавих, арга зүйгээр хангах. Арга хэмжээг оновчгүй тодорхойлсон, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байх шаардлагыг хангаагүй, суурь түвшин тавигдаагүй, зорилтот түвшинг ойлгомжгүй зэрэг дутагдлыг дахин гаргахгүй байх.

Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь:

Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн үнэлгээг 94.0 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа, үр дүнг тухай бүр сайтаар дамжуулан иргэдэд нээлттэй, тогтмол мэдээлдэг байхад анхаарах шаардлагатай.

БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Байгууллагын ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн үнэлгээ:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9 дүгээр хавсралтаар батлагдсан “МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГЛТ”-ээр чиг үүргийн, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал гэсэн гэсэн үзүүлэлтийн дагуу 90.0 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэв.

Тус сумын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд үндэслэж, бодит нөхцөл байдлыг газар дээр нь судалж, вэб сайт, мэдээллийн самбарын хөтлөлт, баяжилтыг харгалзан үзсэн.

Албан ёсны вэб сайтын хөгжүүлэлтийг сайжруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд төсөвт байгууллагуудын мэдээллийг сайтаар дамжуулан иргэд олон нийтэд түгээх ажлыг тогтмол зохион байгуулж ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Цаашид иргэдээс байгууллагын үйл ажиллагааны талаарх санал асуулгыг цаасан болон цахим хэлбэрээр авч хэвших, түүнд иргэдийн оролцоог хангалттай бүрдүүлж ажиллахад анхаарах .

Шударга байдлын түвшний үнэлгээ:

“Сум, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө”-ний жилийн эцсийн биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс үнэлсэн шударга байдлын үнэлгээтэй харгалзан газар дээр нь дүгнэсэн бөгөөд 85.0 хувийн хэрэгжилттэйгээр үнэлэв.

Цаашид:

- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр өөрсдийн нөөц бололцоог ашиглаж шторк, видео бэлтгэж сумын албан ёсны вэб сайтын мэдээллийг тогтмол шинэчлэн

байршуулдаг байх, нөлөөллийн ажлуудыг санаачлан зохион байгуулж, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх

- Авлигийн эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулж, үр дүнг тооцож ажиллах
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс авч хэвших, түүний мөрөөр ажил сайжруулах, алдаа дутагдлаа тухай бүрт нь засах
- Авлига, ашиг сонирхлын эсрэг хууль, тогтоомж, дүрэм журмыг сумын төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, авлигаас ангид байх сургалт, зөвлөгөөнд төрийн албан хаагчдыг хамруулахад анхаарах.
- Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс сумын сайтад байршуулсан мэдээлэл бүрэн бус хангалтгүй байгааг анхааруулсан байна. Иймд мэдээллийг бүрэн байршуулах, шинэчлэлийг тогтмол хийхэд анхаарах.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсээс ирүүлсэн үнэлгээнд тулгуурлан үнэлсэн бөгөөд 91.0 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэлээ.

Цаашид нийтлэг гарч буй алдааг давтан гаргахгүй байхыг бүх шатны төсвийн байгууллагууд, мэдээлэл оруулах эрх бүхий албан хаагчид анхааран ажиллах шаардлагатай.

-Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас өгч буй дүгнэлт, зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлж, хамтран ажиллах, мэргэшлийн зөвлөгөө авах,

-Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг бүрэн оруулж ажиллахад анхаарах шаардлагатай.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн биелэлт:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт үр дүнг 89.0 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэлээ.

Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож ажилласан сайн талтай.

Цаашид төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх, ажлын байран дээр суралцах нөхцөлийг бүрдүүлж, ур чадвараа нэмэгдүүлэхэд анхаарах.

- Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичиг стандарт (MNS 5140:2021)-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр бүх албан хаагчдын мэдлэгийг бататгах, чадавхжуулахад анхаарах. Тухайлбал: Хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, илтгэх хуудас зэргийг стандартын шаардлагад нийцүүлэх мөн захирамжийн бланкыг буруу шифрлэсэн (жишээ нь захирамжийн 2 хувь ижил шифртэй) гэх мэт.

- Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгаас нэгдсэн заавар зөвлөгөө авах ажлыг сумын хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах,

- Төсөвт байгууллагуудыг сумын Засаг даргын Тамгын газраас арга зүйн зөвлөмж, үйл ажиллагааны чиглэлээр сайтар хангаж ажиллах, сургалт мэдээллийг тогтмол хийж байх.

- Шинээр томилогдож байгаа албан тушаалтанг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, чиглүүлэх сургалтын үйл ажиллагааг байгууллага бүр хэрэгжүүлж ажиллах.

Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт:

Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг 79.0 хувийн хэрэгжилттэйгээр дүгнэсэн.

Өнгөрсөн онд нийт 51 иргэнийг шилжиж ирсэн ч 132 иргэн шилжин явсан нь сөрөг бланстай байна. Тус үзүүлэлт нь нээлттэй Өвөрхангай хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан гэж үзэх боломжгүй байна гэж дүгнэлээ. Цаашид шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд шилжин ирэгсдийг нэмэгдүүлэх зорилгоор сум, орон нутгаа сурталчилсан, давуу талаа харуулсан кино, контент богино хэмжээний шторк болон ярилцлага нэвтрүүлгүүдийг цувралаар хийж олны хүртээл болгох шаардлагатай гэж зөвлөж байна. Мөн шилжин суурьшигчдын сэтгэгдлийг сайн жишээ болгон олон нийтэд түгээж ажиллах шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт:

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 89,0 хувьтай дүгнэлээ.

Энэ хүрээнд нэгдсэн хогийн цэгийн үйл ажиллагааг тодорхой хэмжээнд сайжруулах, хогийн цэгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эко орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа тодорхой хэмжээнд хийгдсэн. Мөн ирэх онд тодорхой хэмжээний хөрөнгийг төлөвлөсөн байна. Цаашид анхан шатны эх үүсвэр дээр хогийг ангилан ялгах дадалд иргэдийн хандлагыг хэвшүүлэх, мөн хогийн цэгийн зохистой ашиглалтыг нэмэгдүүлэх, хянах зорилгоор камержуулж, хяналтыг апп ашиглан хийх шаардлагатайг зөвлөж байна.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2023 онд тарьж ургуулахаар 25000 мод төлөвлөснөөс 5590 мод бут тариалсан бөгөөд ургалт 90 хувьтай байгаа нь цаашид тарьж ургуулсан модны нэр төрөл, амьдралтын хувийг нэмэгдүүлэх, тарих үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд төлөвлөхөд анхаарах шаардлагатайг харуулж байна.

Аймгийн хэмжээнд 2024 оныг цахим шилжилтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан оновчтой төлөвлөлтийг хийж, үр дүн гаргаж ажиллахад анхаарах шаардлагатайг зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСЭГ